



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/52

Сүхбаатар сум

### Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажил хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг, Монгол Улсын Шадар сайдын баталсан 2022 оны Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах хуваарь, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд аж ахуй нэгж байгууллага, иргэдийг сургах, харилцан ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн хэмжээнд 2022 оны 2 дугаар улиралд зохион байгуулах гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлыг хангах удирдамжийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад шаардагдах зардлыг дөрөвдүгээр, гүйцэтгэлийн хяналт шалгалтад шаардагдах зардлын тооцоог тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, удирдах бүрэлдэхүүний сургалтад гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангаж, шаардлагатай хөрөнгийг цаг хугацаанд нь шийдвэрлэж сургалт, дадлага сургуулийг үр дүнтэй зохион байгуулж ажиллах талаар аймгийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга, сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ө.Сувдаа)-д даалгасугай.

3. Аймгийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Алтанбулаг, Баянгол, Сүхбаатар, Сайхан, Хүдэр, Мандал, Ерөө сум, "Болд Төмөр Ерөө гол" ХХК, "Бороогоулд" ХХК, "Тод ундрага" ХХК, "Цемент шохой" ХК, "УБТЗ Сүхбаатар зангилаа", "Дархан-Сэлэнгэ" ЦТС ХК, "Сэлэнгэ энерго" ОНӨААТҮГ, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д бэлэн байдлын үзлэг, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт, сургалт зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа Г.Галбадрах/-т үүрэг болгосугай.

4. Бэлэн байдлын үзлэг, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт, сургалт зохион байгуулахад

C:\users\albanbichig2021\zahiramjA4.docx

40810150


6 6

1 1



шаардагдах шатахууны 1,424,880 (сая дөрвөн зуун хорин дөрвөн мянга найман зуун ная) төгрөгний зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (О.Мөнхбаяр), ажлын хэсгийн томилолтын зардлыг Онцгой байдлын газар (хурандаа Г.Галбадрах)-т тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Сайнцог)-т үүрэг болгосугай.



1-7

1-7



Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны  
02 дугаар сарын 14-ны өдрийн А/52  
тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ, ГАМШГААС ХАМГААЛАХ  
БОЛОН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС,  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УДИРДАМЖ**

2022.02.08

Сүхбаатар сум

**Нэг. Зорилго:**

Монгол Улсын Шадар сайдын баталсан 2022 оны “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах хуваарь” –ийн дагуу аймгийн гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалттай мэргэжлийн анги, сумдын ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, шуурхай хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулахад оршино.

**Хоёр. Ерөнхий зүйл**

**2.1. Бэлэн байдлын үзлэгийн чиглэлээр:**

2.1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг зохион байгуулах, үнэлэх журам”,

2.1.2. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, 2017 оны 75 дугаар тогтоол “Мэргэжлийн ангийн дүрэм”, 2018 оны 24 дүгээр тогтоол “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, 67 дугаар тогтоол “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, 120 дугаар тогтоол “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын хэрэгжилтийг тус тус хангуулах,

**2.2. Хяналт шалгалтын чиглэлээр:**

2.2.1. Засаг захиргааны нэгжид Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.1, 8, 13.3.3, 13.3.4, 19.3, 22, 31, 32 дугаар зүйл, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10, 15, 18 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоол “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”,

2.2.2. Хуулийн этгээд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.1, 7.2, 8, 9, 13.3.7, 19.3, 22, 34, 35 дугаар зүйл, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10, 17, 18, 19, 20.1, 21.2, 23 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоол “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”, Барилга байгууламжийн галын

1

2

3



аюулгүй байдал БНБД 21-01-02, Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй байдлын норм БНБД 21-02-02, Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө БНБД 30-02-07, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-11, Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16, Барилгын доторх ус хангамж, ариутгах татуурга БНБД 40-05-16, Барилга байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНБД 21-04-05, Хийн хангамж БНБД 42-01-04, Шатахуун түгээх станц. галын аюулгүйн норм 21-07-14, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм 21-03-04, Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага, хяналтын аргууд MNS GOST R 12.2.143:2013, Авто зогсоол БНБД 21-05-10, Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03, Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566:2020 болон бусад холбогдох галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2.3. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ноогдуулах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.12.10 дахь хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлнэ.

### 2.3. Сургалтын чиглэлээр:

Гамшиг, техникийн холбогдолтой осол, цаг агаарын аюулт үзэгдэл, нурангийн үед шуурхай хариу арга хэмжээ авах, удирдлага зохион байгуулалт мэргэжлийн ангийн харилцан ажиллагааны сургалтыг 3 цагийн хугацаатай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

### **Гурав. Бэлэн байдлын үзлэг, хяналт шалгалт, сургалт зохион байгуулах хугацаа, бүрэлдэхүүн, хамрах хүрээ**

3.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт, сургалтыг 2022 оны 2 дугаар сарын 14-16, 4 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Хүдэр, Ерөө сум "Болд Төмөр Ерөө гол" ХХК, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК,

2 дугаар сарын 16-18, 4 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд Сайхан сум, "Цемент шохой" ХК,

2 дугаар сарын 18-20, 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Баянгол сум "Бороогоулд" ХХК, "Тод ундрага" ХХК,

2 дугаар сарын 20-25, 4 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Сүхбаатар сум, "УБТЗ Сүхбаатар зангилаа", "Дархан-Сэлэнгэ" ЦТС ХК, "Сэлэнгэ энерго" ОНӨААТҮГ -т зохион байгуулна.

3.2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт, сургалтад шаардагдах шатахууны зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлж, алба хаагчдын томилолтын зардлыг Онцгой байдлын газар хариуцна.



3.3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт, сургалтыг Засаг захиргааны нэгжид нэгдүгээр ажлын хэсэг, аж ахуйн нэгж байгууллагад хоёрдугаар ажлын хэсэг зохион байгуулж дүн мэдээг 2022 оны 2 дугаар сарын 28, 5 дугаар сарын 2-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад илтгэх хуудсаар танилцуулна.

**Дөрөв. Удирдамжийн үр дүн, авах арга хэмжээ**

4.1. Аймгийн Онцгой комисст Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ажлын тайланг танилцуулна.

4.2. Онцгой байдлын газраас Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, хяналт шалгалтын дүн, санал дүгнэлтийн талаарх танилцуулгыг шалгалтад хамрагдсан байгууллагуудын харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шат дараатай авч хэрэгжүүлнэ.

---oOo---

